



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/325

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 46 дугаар зөвлөмжийн дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих Спорт заалны барилга /Өвөрхангай, Зүүнбаян-Улаан сум/ ажлыг 589000000 (таван зуун наян есөн сая) төгрөгөөр Смарт зоос ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

3. Гүйцэтгэгч аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100703